



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/299

Мөрөн сум

Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг
хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 60.1.17, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5, 14.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, Аудитын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Хөвсгөл аймаг дахь төрийн Аудитын байгууллагаас аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 1 дүгээр, төсвийн гүйцэтгэлийн тайланд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг зохион байгуулж, удирдлага арга зүйгээр хангаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар), Орон нутгийн өмчийн газар (Х.Цэнд-Аюуш), Сумдын засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэх, мөн сум, байгууллагуудын 2023 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд Төрийн аудитын байгууллагаас өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх, төлөвлөгөөг байгууллагын хэмжээнд гаргаж хэрэгжүүлэн, заасан хугацаанд тайлагнаж, өөрийн төсөвт хамаарах хугацаа хэтэрсэн өр, авлагыг барагдуулж ажиллахыг бүх шатны төсөв захирагч, санхүүгийн ажилтнуудад даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн засаг даргын 2024 оны 06 дугаар сарын 10 ний өдрийн 129 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Сумдын Санхүү албаны дарга, төрийн сангийн мэргэжилтнийг хавсран ажиллахгүй тусдаа албан хаагчдаар гүйцэтгүүлэх, төлбөр тооцоонд тавих хяналт алдагдах эрсдлээс урьдчилан сэргийлэх	-Шаардлага хангасан мэргэжлийн боловсон хүчинтэй болох.	- Сумын засаг дарга	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Авлага өр төлбөрийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж санхүүгийн тайланд тусгах	-тооцоо нийлж өглөг авлага баталгаажуулах	- Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
3	Хөрөнгө хүлээн авахтай холбоотой асуудлыг холбогдох газарт хандаж шийдвэрлүүлэх	- Хөрөнгийн бүртгэл, хадгалалт хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах	-Орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн газар
4	Орон нутгийн өмчит компаниудын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.	-Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	-Санхүү төрийн сангийн -Орон нутгийн өмчийн газар	Орон нутгийн өмчийн газар
5	Төсвийн шууд болон төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн тайлангаар илэрсэн алдаа, зөрчлийг бууруулах, дахин гаргахгүй байхад анхаарч төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг Төрийн аудитын газар болон СТСХ-т хуулийн хугацаанд ирүүлэх.	-Аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн Аудитын байгууллагад хугацаанд нь гаргаж хүргүүлэх.	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс

Аймгийн засаг даргын 2024 оны .06.
дугаар сарын .10. ний өдрийн /2024 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт

АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ӨГСӨН ЗӨВЛӨМЖ ХЭРЭГЖИХ
ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Зөвлөмжийн агуулга	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжилтийг хангах байгууллага	Хэрэгжилтэнд хяналт тавих байгууллага
1	Төсвийг бодит тооцоолол судалгаа, өмнөх оны гүйцэтгэл болон шинээр хэрэгжиж байгаа болон одоо мөрдөгдөж байгаа хууль журманд нийцүүлэн, хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөн саналаа ирүүлэх	-Орон нутгийн төсвийн төслийг холбогдох маягт, аргачлалын дагуу үнэн зөв бэлтгэх, хянуулах, батлуулах	-Санхүү төрийн сангийн хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс
2	Төсвийн орлогыг бүрдүүлэхдээ орлогын тооцоо, судалгааг нэр төрлөөр нь үндэслэлтэйгээр тооцоолон боловсруулж биелэлтийг жигд хангаж, төсвийн захирагчдын хуулиар хүлээсэн үүргийг бүрэн хангаж ажиллах	-Татвар төлөгчдийн хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах -Орлогын сар бүрийн бүрдэлтэд хяналт тавьж гүйцэтгэлийн мэдээллийг ирүүлэх. Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т заасан чиг үүрийг хэрэгжүүлэхгүй байгаа төсвийн төвлөрүүлэн захирагч нарт хариуцлага тооцон ажиллах	-Санхүү төрийн сангийн хэлтэс -Хөвсгөл аймгийн Татварын хэлтэс - Бүх шатны төсөв захирагчид	Санхүү төрийн сангийн хэлтэс